



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/05

Шивээговь сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.5.2, 16 дугаар зүйлийн 16.1.3, 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутагт Ихэр улаан толгой гэх газарт, малчны хотноос малын гоц халдвар мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн нь тогтоогдсон тул 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн Шивээговь сумын харьяа голомтын бүсэд багтах хэсэгт, ойр орчмын 5 километр газарт 21 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Гоц халдварт мялзан өвчний хязгаарлалтын дэглэм цуцлах хүртэл хязгаарлалтын бүсэд хүн, техник хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөн хийхийг бүрэн хориглосугай.

3.Хязгаарлалтын дэглэмийн үед авах арга хэмжээний ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, хяналтын пост ажиллуулах хуваарийг 2 дугаар хавсралтаар, голомтын бүс дэхь мал бүхий иргэдийн байршлаар хөдөлгөөнт эргүүл хийх ажлын хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Хязгаарлалтын бүс тогтоож, малын эмч, малчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, заавар зөвлөгөө өгөх, тандалт үзлэг хийх, хорио цээрийн бүс рүү хүн, мал, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Дашдэлэг)-т, хязгаарлалтын бүсэд байгаа малд үзлэг, ариутгал халдваргүйтгэл хийхийг “Хийморь Алтай групп” ХХК-ийн захирал (А.Цэрэндолгор)-т, ажлын гүйцэтгэл, явцыг тухай бүр баримтжуулж, аймгийн Мал

эмнэлгийн газар, Онцгой байдлын газар болон дээд шатны байгууллагад тогтмол дамжуулж мэдээллэхийг Онцгой комиссын гишүүн (Ш.Буяаннэмэх) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Ч.Сугармаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *П.ГАНЧИМЭГ* П.ГАНЧИМЭГ



12

Сумын Засаг даргын 2023 оны 01-р сарын 07-ны өдрийн 105 дугаар захирамжийн 1.1-р хавсралт



ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хийгдэх ажил		Хариуцах эзэн
1	Хязгаарлалт тогтоох Засаг даргын захирамж		Сумын Засаг дарга
2	Зохион байгуулалт		Сумын Онцгой комисс
3	Салбар хоорондын уялдаа холбоо		ЗДО
		Айл өрхийн байршлын солбилцол тогтоох	Газрын даамал
4	Санхүүжилт, санхүүгийн нөөц		Санхүү алба
5	Үзлэг, тархвар зүйн судалгаа		МЭТ
6	Дархлаажуулалт		МЭНэгж
7	Хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслэлийн шилжилт хөдөлгөөнийг хянах	Мал, зэрлэг амьтны байршил хөдөлгөөнийг тандах	МЭТ
			МЭТ, Цагдаагийн хэсэг, багийн Засаг дарга
8	Ариутгал халдваргүйтгэл		МЭТ, МЭН
9	Нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа	Нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээлэлээр бусад байгууллагыг хангах	МЭТ
			Мэдээллийн ажилтан
10	Яаралтай дуудлага үйлчилгээнд бэлэн байх		МЭН